**МОНГОЛ УЛС**
**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 09 өдөр　　　　Дугаар А/466　　　　Есөнбулаг

**Комисс томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн БХБЯ/202212064 тоот гэрээтэй Халиун сумын цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

| | | |
|---|---|---|
| Комиссын дарга: | Б.Бямбадорж | (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд ерөнхий архитектор) |
| Гишүүдэд: | М.Мандахсүү | (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга) |
| | П.Аззаяа | (Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч) |
| | Г.Золзаяа | (Эрүүл мэндийн газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч) |
| | Ч.Лхагвадулам | (Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн) |
| | Т.Алтанхуяг | (Халиун сумын Засаг даргын орлогч) (ашиглагч) |
| | Б.Бээжин | ("Алтай-Улиастайн Эрчим Хүчний систем" ТӨХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер) |



0201050621

Г.Хүрэлхүү (“Ундарга-Алтай” ААТҮГ-ын ерөнхий инженер)

Д.Өлзийбаяр (“Чанарын түншлэл” ХХК-ийн технологич инженер) (зохиогч)

Ц.Алтан-Очир (“Жаргалант дулаан” ХХК-ийн ерөнхий инженер) (гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:М.Мөнхцэцэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн барилга байгууламж хариуцсан мэргэжилтэн)

2.Цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг ханган, хүлээн авч, үр дүнг 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), барилга байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Халиун сумын Засаг дарга (Ж.Мянганбаяр)-д тус тус даалгасугай.

ОРЛОГЧ Г.ЧИНБАТ

[illegible]